

БАТЛАВ  
“УБЦТС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

БАТЛАВ  
“ОРГИХЫН БУЛАГ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Б.АЛТАНХУЯГ

**2021/200 ДУГААРТАЙ КАСК НҮҮРЭВЧ МАЛГАЙ, ГАГНУУРЧИНГИЙН  
ХУВЦАС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

Дугаар №

2021/290

2021 оны 09 дүгээр сарын 14

Улаанбаатар хот

Нэг талаас “УБЦТС” ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ОРГИХЫН БУЛАГ” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх)-ийн хооронд 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан 2021/200 дугаартай гэрээнд нийлүүлэгч нь каск нүүрэвч малгай, гагнуурчингийн хувцас (цаашид “бараа” гэх)-ыг 2021 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулсан.

Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.3.7 дахь заалт, “Оргихын булаг” ХХК-ийн 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 298/21 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1. 2021/200 дугаартай үндсэн гэрээний 4 дүгээр зүйлд заасан “2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн дотор гүйцэтгэж хүлээлгэж өгнө.” гэснийг 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гүйцэтгэж хүлээлгэж өгнө.” гэж гэрээний хугацааг өөрчлөв.
2. Энэхүү гэрээний өөрчлөлт нь 2021/200 дугаартай гэрээний салшгүй хэсэг болно.
3. Гэрээний хугацааг сунгасан нь 2021/200 дугаартай гэрээний бусад заалтыг хөндөөгүй болно.
4. Талууд 2021/200 дугаартай үндсэн гэрээний бусад заалтыг дагаж мөрдөнө.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН  
ДЭД ЗАХИРАЛ

О.ОТГОНБАЯР

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

О.АРИУНБОЛД

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА

Ш.ОЮУНЧИМЭГ

ЗХНХ-ИЙН ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.УРАНГОО

Утас: 343420-122

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо

Чингисийн өргөн чөлөө-45.

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗАХИРАЛ

Б.АЛТАНХУЯГ

Утас: 99091391

Хаяг: Хан-Уул дүүрэг, 15-р хороо,

Үйлдвэр 2-ХД гудамж, 58-4 тоот